



СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2023 оны 11 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

Тус хэлтэс нь 2023 оны байдлаар Нийгмийн даатгалын тухай хууль болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Улсын их хурал, Засгийн газар, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны болон Нийслэл, Дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргын тушаал, шийдвэрийн биелэлтийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллав.

Нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь тавьж олгох, ажил олгогч, даатгуулагч иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх, дотоодын хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн үр дүнг дээшлүүлэх, 2023 оныг нийгмийн даатгалын салбарын хэмжээнд “Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил” болгон зарласан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ажил үйлчилгээгээ төлөвлөн явуулж ажиллаа.

**НЭГ. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт,
зарцуулалтын талаар**

Тус хэлтэс 2023 оны тодотгосон төсвөөр нийгмийн даатгалын санд 517.08 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын санд 87.0 тэрбум төгрөг нийт 604.08 тэрбум төгрөг хуримтлуулахаас гурав улиралын байдлаар нийт 433.44 тэрбум төгрөгийн хуримтлуулж, жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 170.64 тэрбум төгрөгийг хуримтлуулж сангийн орлогын төлөвлөгөөг 101.3 хувиар биелүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Сар	Төлөвлөгөө /тэрбум төгрөгөөр/			Гүйцэтгэл / тэрбум төгрөгөөр /			Биелэл тийн хувь /сараар/	Төлөв лөгөө /улира лаар/	Гүйцэт гэл /улира лаар/	Биелэл тийн хувь /улира лаар/
	НДСан	ЭМД сан	Нийт	НДСан	ЭМД сан	Нийт				
1	30.17	7.25	37.42	33.50	6.04	39.54	105.6			
2	32.16	7.25	39.41	36.63	6.89	43.52	110.4			
3	42.96	7.25	50.21	40.57	7.67	48.24	96.0	127.05	131.3	103.3
4	38.94	7.25	46.19	41.56	7.73	49.29	100.2			
5	41.81	7.25	49.06	41.94	7.87	49.81	101.5			
6	47.66	7.25	54.91	47.45	8.87	56.32	102.5	150.17	155.42	103.4
7	41.19	7.25	48.44	36.19	6.76	42.95	88.6			
8	45.46	7.25	52.71	43.91	8.25	52.16	98.9			
9	45.80	7.25	53.05	43.44	8.17	51.61	97.2	154.21	146.72	95.1
10	45.28	7.25	52.53	44.89	8.43	53.32	101.5			
11	47.48	7.25	54.73	53.50	5.16	58.66	107.1			
12	58.17	7.25	65.42	53.50	5.16	58.66	107.1	172.63	170.64	98.8



СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

Нийт	517.08	87.0	604.08	517.08	87.0	604.08	101.3		100.1
------	--------	------	--------	--------	------	--------	-------	--	-------

2023 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг сан тус бүрээр нь авч үзвэл:

- Тэтгэврийн даатгалын сангаас 22227 тэтгэвэр авагчдад 186.0 тэрбум төгрөгний тэтгэвэр.
- Тэтгэмжийн даатгалын сангаас 24844 даатгуулагчдад 19.3 тэрбум төгрөгний тэтгэмж олгосноос:
 - Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 16376 даатгуулагчдад 3.7 тэрбум төгрөгний
 - Жирэмсэн амаржсаны тэтгэмж 5990 даатгуулагчдад 16.9 тэрбум төгрөгний
 - Оршуулгын тэтгэмж 2478 даатгуулагчдад 4.1 тэрбум төгрөгний
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 249 даатгуулагчдад 1084.7 сая төгрөгийг олгосноос:
 - Тахир дутуугийн тэтгэврийг 114 даатгуулагчид 1100.0 сая төгрөгний
 - Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 112 даатгуулагчдад 166.6 сая төгрөгний
 - Тэжээгчээ алдсаны 15 тэтгэвэр авагчдад 81.9 сая төгрөг
- Ажилгүйдлийн даатгалын сангаас 2068 даатгуулагчдад 7.9 тэрбум төгрөгний ажилгүйдлийн тэтгэмжийг тус тус олгосон байна.

ХОЁР. Нийгмийн даатгалын хамралт, нийгмийн даатгалын тайлан хүлээн авалт, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн талаар

2023 онд нийгмийн даатгалын мэдээллийн баазыг Улсын бүртгэлийн баазтай холбосноор мэдээллийн санд даатгуулагчийн буруу орсон регистр, овог нэр үндсэн мэдээллийг засварлах ажил хийгдэж байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооны тайланг 100% интернэтээр авах зорилт тавьж ажилласны үндсэн дээр шимтгэлийн программ хангамжид нийт 14769 байгууллага бүртгэлтэй байна. Тоон гарын үсгээр тайлан өгөх ажлыг идэвхижүүлсээр сар бүр дунджаар 1391 аж ахуйн нэгж, байгууллагаас тоон гарын үсгээр ирж байгаа тайлангуудыг журмын дагуу хүлээн авч хэвшсэн байна.

Сар	Өглөг авлагын тайланд бүртгэлтэй аанб тоо	Тайлан өгсөн ААНБ тоо	Тоон гарын үсгээр тайлан өгсөн аан тоо	Заавал даатгуулагчийн тоо	Сайн дурын даат тоо
1-р сар	9625	6489	1351	103724	5352
2-р сар	9707	6342	1365	108035	5594
3-р сар	9778	6361	1351	113531	5809
4-р сар	9866	6667	1383	119271	6185
5-р сар	9885	6797	1395	119849	6372
6-р сар	9904	6927	1410	120427	6559



СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

7-р сар	10074	6654	1379	135979	6800
8-р сар	10135	6689	1399	141195	6999
9-р сар	10205	6731	1391	147473	7202
10-р сар	10264	6781	1411	154064	7461
11-р сар	10314	6839	1431	154336	7575
12-р сар	10354	6889	1451	154536	7689

2023 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр шинээр 772 аж ахуйн нэгж, байгууллагын 3031 заавал даатгуулагчийг нийгмийн даатгалд хамруулан ЗНД-7, ЗНД-8 тайланг хүлээн авч, 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжих “Нийгмийн даатгалын багц” хуулийн талаарх зөвлөгөө, мэдээ мэдээллийг өгч ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар албан журмын даатгуулагчаар 154536 даатгуулагчийг хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. 2022 оны эцэст 6802 аж ахуйн нэгж, байгууллага тайлан өгч тооцоо хийж байсан бол 2023 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 10354 байгууллага өр авлагын тайланд бүртгэгдсэнээс 6889 аж ахуйн нэг байгууллага тайлан өгч тооцоо хийж байгаа нь нийгмийн даатгалд хамрагдалтын хувь өмнөх оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад 101.2 хувь байна.

Цахим тайлан авах ажлыг зохион байгуулж нийт 14006 ажил олгогчид цахимаар тайлан өгөх нэвтрэх кодыг олгосноор, идэвхитэй тайлан өгч байгаа нийт 6731 ажил олгогч, үүнээс 1411 аж ахуйн нэгж тоон гарын үсгээр тайлан өгч байна.

2023 онд мэдээллийн санд бүртгэгдсэн:

Нийт ажил олгогчийн тоо	-14769
Өглөг авлагын тайлангаар	-10354
Үүнээс Тайлан өгч байгаа	-6889
Үйл ажиллагаа зогсоосон, татан буугдсан, дампуурсан, сураггүй болсон	-7525
Заавал даатгуулагчийн тоо	-154536
Сайн дурын даатгуулагчийн тоо	-7689
ЭМД-д нийт хамрагдсан даатгуулагчдын тоо	-171763

2023 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр мэдээллийн сангийн үнэн зөв бүрдүүлэлтэд хяналт тавьж ажилласнаар буруу тайлагнасан цалин, даатгуулагчийн төрөл кодод 512 аж ахуйн нэгж байгууллагын 616.01 сая төгрөгний залруулга хийв. Мөн сайн дурын ногдуулалт төлөлт зөрүүтэй 542 даатгуулагчийн баримтад шалгалт хийж 78,6 сая төгрөгийг залруулан мэдээллийн санд зөв дүнгээр оруулсан. Дотоодын хяналт шалгалтаар Цахим хяналтын програмаас даатгуулагчийн төрөл буруу орсон мэдээллийг шүүж залруулгын баримт бүрдүүлэн засаж байна. Мөн нийгмийн даатгалын санд бүртгэлтэй 4810 гадаадын иргэдийн үндсэн мэдээллийг хур системд нийцүүлэн засварлаж, шимтгэлийн программд бүртгэлтэй УБЕГазрын баазад бүртгэлгүй 1363, ажил олгогчийн регистр давхардсан 1189 байгууллагын мэдээллийг шалгах засварлах ажлыг гүйцэтгэтгэн тоон мэдээг гарган 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор хүргүүлэхээр ажиллаж байна.

Мэдээллийн санд буруу орсон 292 даатгуулагчийн овог нэр, регистрийг Улсын бүртгэлийн болон архивын лавлагаа, нийгмийн даатгалын дэвтэр, иргэний үнэмлэхийг үндэслэн нэгтгэж засав.



ГУРАВ. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага барагдуулалтын талаар

2022 оны жилийн эцсийн байдлаар 64.5 тэрбум төгрөг байснаас 2023 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр шимтгэлийн өр 79.0 тэрбум төгрөг болж 22.4 хувиар өссөн дүнтэй байна. Үүнээс урсгал авлага 31.4 тэрбум төгрөг, 120 хоногоос дээш насжилттай авлага үүсгэсэн 2980 аж ахуйн нэгжийн 47.6 тэрбум төгрөг байна. Жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлагын хэмжээг өмнөх улиралаас 30 хувиар буюу 16.8 тэрбум төгрөгөөр бууруулахаар ажиллаж байна.

“Нийгмийн даатгалын шимтгэлийг үүссэн хугацаагаар нь ангилах журам”-ын дагуу өр авлагыг ангилж, судалгааг гаргахад, нийт зогсоогдсон 7105 байгууллагаас авлага үүсгэсэн 978 байгууллагын 343.1 мянган төгрөг, өглөг үүсгэсэн 1743 байгууллагын 326.8 мянган төгрөгийн өглөгийн судалгааг хийж, оны эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр эрэн сурвалжлуулах 244 аж ахуйн нэгжийн 2.8 тэрбум төгрөг, шүүхэд хянан шийдвэрлүүлэхээр 11 байгууллагын 7.1 тэрбум төгрөгийн шимтгэлийн төлбөрийг албадан гаргуулах нэхэмжлэлийг шилжүүлэхээр ажиллаж байна. НШШГГазартай хамтран ажиллаж гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа нийт 24 байгууллагын 2.7 тэрбум төгрөгийн авлагыг өглөг авлагын дэлгэрэнгүй тулгалт хийж бүрэн төлөлт хийсэн 3, хэсэгчилэн төлөлт хийсэн 10 аж ахуйн нэгжээс 2023 онд 146.8 сая төгрөг, нийт 231.5 сая төгрөгийн төлбөр төлөгдөж, 2.4 тэр төгрөгийн үлдэгдэлтэй байна. Гүйцэтгэх ажиллагаа хийгдэхгүй удаашралтай байгаа аж ахуйн нэгжийн талаар холбогдох уулзалт хийхэд:

- Түдгэлзүүлсэн төлөвтэй-2
- Хөрөнгө байхгүй-3
- Эрэн сурвалжилж байгаа-2
- Эцсийн өмчлөгч гадаадын иргэн нас барсан-1
- Дампуурлын хуулийн дагуу шүүхэд хүсэлт гаргасан 1 буюу нийт 9 аж

ахуйн нэгжийн 975.7 сая төгрөгийн нэхэмжлэлд гүйцэтгэх ажиллагаа хийгдэх боломжгүй байдалтай байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тэрбум төгрөгөөс дээш өртэй 7 аж ахуйн нэгжийн 15.0 тэрбум төгрөгийн шимтгэлийн өр үүсгэсэн аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудтай холбогдох уулзалтуудыг хийж “Таван толгой түлш” ХХК нь ондоо багтаан төлбөр барагдуулах, “Дөрөвдүгээр эмнэлэг” ХХК 2023 оны 12 дугаар сард 300.0 сая төгрөг, үлдэгдэл төлбөр дээр нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах гэрээ хийхээр, “Өндөр алтайн зам” ХХК, “Насны зам” ХХК, “Уул уурхайн үндэсний олборлогч” ХХК-ийг хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлүүлж, “Жунсонконстракшн” ХХК 2023 оны 11.12 дугаар сард 208.0 сая төгрөгийг төлөх, үлдэгдэл төлбөрийг нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах гэрээ байгуулахаар, “Наранмандал интерпрайзеис” ХХК 2023 оны 11.12 сард 1.5 тэрбум төгрөг төлбарагдуулах, үлдэгдэл төлбөр дээр нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах гэрээ хийхээр эцэслэн шийдвэрлэсэн.

Нийгмийн даатгалын шимтгэлийн 100 саяаас дээш төгрөгийн өр үүсгэсэн 112 аж ахуйн нэгжийн 27.2 тэрбум төгрөгийн авлага байна. Нийгмийн даатгалын авлага барагдуулах арга хэмжээ авагдсан байдлыг авч үзвэл:



- Уулзалт хийсэн-30
- Албан шаардлага-14
- Харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоосон-71
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах гэрээ байгуулсан-65
- Зөрчлийн хэрэг үүсгэсэн-2
- Шүүхэд шилжүүлсэн-8 байгууллага байна.

Авлага нэмэгдэж байгаа гол шалтгаан нь 2020-2022 онд ковидын нөхцөл байдлаас үүссэн эдийн засгийн хямрал арилаагүй, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь 3 хувиар, мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн, улирлын чанартай барилга, зам засвар, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд ковидын өмнөх төсвөөр ажил үйлчилгээ үзүүлэх боломжгүй болсон тул төсөвт тодотгол хийлгүүлэхээр хүлээгдэж байгаа, шатахууны үнийн зөрүүгийн алдагдал, шинээр үүсэх нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхгүй өр нэмэгдүүлэх болон аж ахуйн нэгжүүд өмнөх жилүүдийн хийсэн ажлын гүйцэтгэлээ, Сангийн яамнаас авч чадахгүй байгаа болон хөлсөөр ажил гүйцэтгэсэн санхүүжилт байхгүй, орлого орж ирэх боломжгүй, хөрш улсуудийн хил хаалттай зэрэг нь бизнесийн үйл ажиллагааг сэргэхгүй, нүүрсний болон, хөгжлийн банкны хэрэгт холбогдогчоор татагдсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоож хууль шүүхийн шатанд шалгагдаж байгаа зэрэг эдийн засгийн суурь шалтгаан нөхцлүүдээс үүдэн урсгал авлага өсч байна. Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 550 мянган төгрөг болж нэмэгдсэн нь, авлагын үлдэгдэл оны эхнээс өндөр дүнгээр огцом өссөн тоон үзүүлэлт харагдаж байгаа нэг шалтгаан болж байна. Аж ахуйн нэгж байгууллагууд нь график гарган хуримтлагдсан өр авлага барагдуулах гэрээ хийж байгаа боловч дээрх суурь нөхцөлөөс шалтгаалан тухайн сард шинээр үүсч байгаа шимтгэлийг төлж чадахгүй байгаа тохиолдлууд их байна.

Үзүүлэлт		2023 онд НДШ-н авлага барагдуулах журмын дагуу авсан арга хэмжээ			
		ААН	Өрийн хэмжээ	ААН	Барагдуулсан
"НДШ-н авлага бууруулах журмын дагуу авсан арга хэмжээ"	Уулзалт хийсэн аж ахуйн нэгж байгууллага	74	8.5 тэрбум ₮	35	638.7 сая ₮
	Өр барагдуулах УБ-н албан шаардлага өгсөн	74	4.0 тэрбум ₮	12	652.1 сая ₮
	Харилцах дансны зарлагын гүйлгээг хаасан	2644	64.9 тэрбум ₮	1381	19.5 тэрбум ₮
	Журмын дагуу гэрээ байгуулж графикайн дагуу барагдуулсан	451	34.0 тэрбум ₮	248	13.6 тэрбум ₮
	Шүүхийн шийдвэр гаргуулсан /гүйцэтгэх хуудас гарсан/	23	2.7 тэрбум ₮	3	146.8 сая ₮



**Дөрөв. Эрүүл мэндийн даатгалын сангийн төлөвлөгөө,
биелэлт, хамрагдалтын талаар**

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хооронд байгуулсан “Хамтарсан чиглэл хүргүүлэх тухай” чиглэлийг хэрэгжүүлж, Эрүүл мэндийн даатгалын санд 2023 онд нийт 87.0 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөг сар, улирал бүр жигд ханган биелүүлэхээс ажил олгогч даатгуулагчаас 83.8 тэрбум, бусад 3.8 тэрбум төгрөгийн орлогын татан төвлөрүүлэх зорилт тавин ажиллаж байгаагаас 2023 оны гуравдугаар улиралын байдлаар нийт 76.0 тэрбум төгрөг хуримтлуулж, жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 11.0 тэрбум төгрөгийг хуримтлуулж сангийн төлөвлөгөөг биелүүлэхээр ажиллаж байна. Эрүүл мэндийн даатгалын хуримтлуулсан орлогыг төвлөрсөн харилцах дансанд тогтоосон хугацаанд бүрэн зөв хуваарилан ажиллалаа.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдагсдын тоог харуулбал: /жилээр/

Нийгмийн даатгалд хамрагдагсад

01	Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагч	154073
10	Нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагчид	7575
		161648

ЭМД-ын заавал болон сайн дурын даатгалд хамрагдагсад

02	Аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	1
04	Мэргэжлийн сургуульд суралцагч	847
09	Малчин	0
12	Хоригдол	0
15	Гадаадын харъяалалтай иргэн	207
16	Нөхөн олговор авагч	0
18	Ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн	14954
99	Бусад /ОХУ-н ЭМД-ыг сайн дураар төлөгч/	0
		16009

Нийгмийн даатгалд хамрагдагсад

88	Нийгмийн даатгалд хамрагдагсад	171763
----	--------------------------------	--------

Нийт дүн: 177657

Тус хэлтэст бүртгэлтэй 26 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд бүх сургуулиудтай хамтран ажиллах санамж бичгийг байгуулж ажилласан. Мөн нийт 14 их дээд сургуулийн 1152 оюутан сурагчдад “Даатгалтай ирээдүй” сэдэвт сургалт зохион байгуулж ажилласан.

2023 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр ЭМДаатгалд тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй 14954 иргэн, 847 оюутан суралцагч гадаадын



харьяалалтай 207 иргэний хамруулсан байна. ЭМД-ын үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх ажлын хүрээнд дүүргийн иргэдээс гадна аймаг, хөдөө орон нутгийн иргэдийг харьяалал харгалзахгүй хүлээн авч түргэн шуурхай үйлчилж байна.

2023 онд эрүүл мэндийн даатгалын цахим үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг байцаагч нарын цахим хөтөчөөр дамжуулан зөвлөгөө өгч, ИБаримт системээр төлөлт хийх талаар даатгуулагчидад мэдээлэл өгч, 2019 оноос эхлэн эрүүл мэндийн даатгалын хураамжийг албан журмаар нөхөн төлүүлж ажиллаж байна

ТАВ. Нийгмийн даатгалын сайн дурындаатгалын сангийн төлөвлөгөө, биелэлтхамралтын нэмэгдүүлэх талаар

2023 оны сайн дурын даатгалд 6452 даатгуулагчийг хамруулж нийт 9.0 тэрбум төгрөг хуримтлуулахаас гуравдугаар улиралын байдлаар 7575 даатгуулагчаас 7.29 тэрбум төгрөг хуримтлуулж, жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1.7 тэрбум төгрөгийг нэмж хуримтлуулахаар ажиллаж байна.

2022 оны эцэст сайн дурын даатгалын өглөг 181.8 сая төгрөг байсан бол 2023 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 96.1 сая төгрөг болж 85.7 сая төгрөгөөр буурсан. Сайн дурын даатгалд шинээр 2698 даатгуулагчийг, 0-3 насны хүүхдээ асарч байгаа 293 ээжийг хамруулсан байна.

2023 онд мэдээллийн сангийн үнэн зав бүрдүүлэлтэд хяналт тавьж ажилсаны үр дүнд сайн дурын ногдуулалт, төлөлт зөрүүтэй 542 даатгуулагчийн баримтад шалгалт хийж залруулан 78.6 сая төгрөгийн залруулга хийж, мэдээллийн санд оруулсан байна.

Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд УБЕГазрын хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн газраас Сүхбаатар дүүргийн хаягийн бүртгэлтэй шинээр бүртгүүлсэн 2124 аж ахуйн нэгж байгууллагын судалгааг авч 234 байгууллагыг шимтгэл төлөгчөөр бүртгэсэн. Татварын байгууллагад тайлан илгээж байгаа боловч нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан өгөхгүй байгаа аж ахуйн нэгжүүдийг хамруулах зорилгоор Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 238 дугаартай албан хүсэлт хүргүүлж, одоогоор хариу ирүүлээгүй байна.

Сүхбаатар дүүргийн Халамжийн хэлтэст “Цалинтай ээж” хөтөлбөрт хамрагдаж байгаа 4239 ээжийн судалгааг авч, нийгмийн даатгалд хөнгөлттэй нөхцөлөөр хамрагдаж болох талаар 701 ээжтэй утсаар холбогдож үүнээс 211 ээжийн гэрээг шинээр байгуулж, мэдээлэл хүргэж ажилласан. Мөн Гэр бүл хүүхэд хөгжлийн газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай хамтран “Career-Expo 2023” залуусын нэгдсэн хөдөлмөрийн өдөрлөгийн үйлд ажиллагаанд хамтран оролцож, Сүхбаатар дүүргийн 8 их дээд сургуулийн 2000 гаруй оюутан суралцагчдад нийгмийн даатгалын ач холбогдолын талаар мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан байна.

ЗУРГАА. Хяналт шалгалтын ажлын талаар

2023 онд нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, хөдөлмөрийн хөлсний сан түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлсон байдал, нийгмийн даатгалын шимтгэл хураамжийн ногдуулалт, төлөлт, тайланг хугацаанд нь тушааж буй байдлыг нийт 201 ажил олгогчийн 3403 даатгуулагчийг хамруулан, улсын байцаагчийн актаар 59 ажил олгогчид 155,6 сая төгрөгийн хөдөлмөр хөлс түүнтэй



адилтгах орлогын төлбөр зөрчлийн дүнгээс 54,6 сая төгрөгийн шимтгэл нөхөн төлүүлж, түүнээс 78,0 сая төгрөгийн алданги ногдуулж нийт 133,1 сая төгрөгийн төлбөр зөрчлийн дүнг 100% хувь барагдуулаад байна.

Нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь төлдөггүй, тайланг хугацаандаа тайлагнаагүй даатгуулагчийн эрх ашгийг хохироосон нийт 105 ажил олгогч байгууллагын захирал, нягтлан бодогчдод Зөрчилын тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.1, 10.17.2, 10.17.3, 10.17.4, 10.17.5 заалтын дагуу шийтгэврийн хуудсаар 33.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.

Дотоодын хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу 2023 онд шинээр тогтоогдсон 1001 өндөр насны тэтгэвэр авагчийн 885.2 сая төгрөг, тэжээгчээ алдсаны 80 тэтгэвэр авагчийн 43.9 сая төгрөг, тахир дутуугийн 295 тэтгэвэр авагчийн 161.4 сая төгрөг нийт 1376 тэтгэвэр авагчийн 1090.5 сая төгрөгийн тэтгэврийн хувийн хэргийг шалгав. Үүнээс ажилласан хугацааг нотлох тушаалын хуулбар авах, сайн дурын даатгуулагчийн цуцласан гэрээг хавсаргах болон цалин буруу шивсэн, хувийн хэргийн хавтсанд хүлээж авсан материалын бүрдүүлэлтийг тэмдэглэдэггүй, ажилласан жил буруу тооцох зэрэг зөрчил гарсныг тухай бүр хариуцсан байцаагчаар нь засаж залруулан хянан шалгаж ажиллаж байна.

Мөн ХЧТА -14869 даатгуулагчийн 3549.8 сая төгрөгийн тэтгэмж, жирэмсний болон амаржсаны 5361 даатгуулагчийн 15803.5 сая төгрөгийн, YOMШӨ-н ХЧТА-127 даатгуулагчийн 176.5 сая төгрөгийн, сайн дурын даатгуулагчийн 604 хөдөлмөрийн чадвар түр алдсаны 328.7 сая төгрөгийн, 391 жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн 611.2 сая төгрөгийн нийт 21352 даатгуулагчийн эмнэлгийн хуудасыг шалгаж 20469.7 сая төгрөгийн тэтгэмжийг хянаж олгуулав. Шалгалтын явцад цалингийн дундаж буруу тооцох, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжтэй байгаа даатгуулагчийн цалинд төрөл буруу сонгох, шимтгэл төлөхгүй байх зэрэг зөрчлүүд илэрч тухай бүрд засаж залруулан ажиллаа. Мөн хяналтын monitoring программаар тэтгэмжийн бодолтын мэдээлэлийн бааз дээр байгаа алдааг шалгаж тайлбар шалтгааныг нь байцаагч тус бүрээр бичиж хааж байгаа.

Тайлант хугацаанд 2116 даатгуулагчдын 4232.0 сая төгрөгийн оршуулгын тэтгэмжийн олголт бодолт болон ажилгүйдлийн даатгалын сангаас 1822 хүнд олгосон 8098.8 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжинд шалгаснаас ажилгүйдлийн тэтгэмж авах хугацаандаа ажил хийсэн, цалин буруу шивсэн, цалинг нэгдсэн мэдээллийн санд шивээгүй бодолт хийсэн, ажилласан жилийг нотлох баримт дутуу зэрэг зөрчлийг байсныг хариуцсан байцаагчаар тухай бүр нь засаж залруулав.

Дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн төлбөр зөрчил:

- Тэтгэмжийн даатгалын санд 51 даатгуулагчийн 26.8 сая төгрөгийг 100% төлүүлсэн.
- Тэтгэврийн даатгалын санд 82 иргэнтэй холбоотой 414.2 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс дүнгээс 192.4 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж, барагдаагүй төлбөр 221.5 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, мөн хуулийн дагуу 50% хүртэлх хэмжээгээр суутган төлүүлж ажилласан.

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга. нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу хэлтсийн даргын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/24 тоот “Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нэвтрэн



мэдээлэл, хяналт тавих ажилтныг томилох тухай” тушаалаар томилогдсон албан хаагчид нь байгууллагын үйл ажиллагааны 28 төрлийн 129 мэдээлэл, Нийгмийн даатгалын сангийн 28 төрлийн 129 мэдээллийг тухай бүр, сар бүр, улирал бүр, хагас жил бүр, жил бүр гэсэн давтамжтайгаар үнэн зөв, хуулийн хугацаанд бүрэн байршуулж байна. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт тус тус цахимаар дараа сарын 8-ны дотор хавсралтанд заасан маягтын дагуу байршуулж байгаад хяналт тавьж ажиллаж байна.

Эмнэлгийн хөдөлмөр магадлах комисс нь даатгуулагч иргэдийн хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох асуудлыг магадлан шийдвэрлэж эхний 9 сарын байдлаар 9 өдөр буюу 78 цаг хуралдаж, 95 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шинээр тогтоох, 267 хүний хувь хугацааг сунгах, хөдөлмөрийн чадвар алдалт тогтоох нөхцөл шаардлагыг хангахгүй 10 хүнийг материал нөхөн бүрдүүлэхээр, эсвэл шийдвэрлэхээс татгалзаж буцаах, биеийн байдал сайжирсан, хяналтын хугацаа дууссан, өндөр насны тэтгэвэр тогтоолгох зэрэг шалтгаанаар 15 иргэний хувь хугацааг цуцлах байдлаар нийт 377 даатгуулагчийн асуудлыг шийдвэрлэж ажилласан байна. Мөн иргэний харьяаллын дагуу шилжиж ирсэн 13, шилжиж явсан 7 иргэний шилжилт хөдөлгөөнийг эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийг санд хийж ажиллав.

- “Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах” №01 тоот удирдамж дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ээс 2022 оны 12 дугаар сарын 31-ныг дуустлах хугацааны 5078 ажилгүйдлийн тэтгэмжийг шалгаж зөрчилтэй байж магадгүй 48 даатгуулагчийн жагсаалтыг гаргасан.
- “Аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг шалгах” №02 тоот удирдамжийн дагуу нийт ажил олгогчийн массив 9785, үйл ажиллагаа зогссон 2912, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг 6873 аж ахуй нэгж байгууллагын тайланг шалгасан.
 - Мэдээллийн баазаас 3-НД7, 3-НД8 тайлан зөрсөн 16
 - Байгууллагын тамгагүй 893
 - Байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсэггүй 837
 - Дутуу тайлан 16
 - Нөхөнгийн тайлангийн албан бичиг баримт, цалин залруулгын баримт, карт зэрэг тайланд хавсаргаагүй 59
 - төрөл буруу тайлагнасан 1646 зөрчлийг илрүүлж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.
- “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг, шимтгэлийн хуримтлагдсан авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, хамралтыг нэмэгдүүлэх” №03 тоот удирдамжийн дагуу 121 хоногоос дээш шимтгэлийн хуримтлагдсан өртэй 792 аж ахуй нэгж байгууллагын 48.2 тэрбум төгрөгийн шимтгэлийг барагдуулан ажиллахаас 2023 оны байдлаар шимтгэлийн хуримтлагдсан өртэй 272 байгууллагын 13.7 тэрбум төгрөгийн авлагаас 7.8 тэрбум төгрөгийн өрийн барагдуулж 5.8 тэрбум төгрөгийн авлага үлдсэн байна. Удирдамжаар баталсан байгууллагын жагсаалтаас 792 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлага 46.7 тэрбум төгрөгөөс



25.4 тэрбум төгрөг барагдуулсан боловч шинээр шимтгэлийн авлага 46.9 тэрбум төгрөг болсон байна.

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн “Урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийх нэгдсэн удирдамж”-н дагуу Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсээс 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тогтоон авч байгаа 2355 иргэдийн судалгааг гаргуулж тус хэлтсээс тэтгэвэр авагч буй 22014 тэтгэвэр авагчийн мэдээлэлтэй тулган шалгаж 7 иргэнийн 31.7 сая төгрөгийн төлбөр зөрчлийг Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлж Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт улсын байцаагчийн акт тавигдсан.
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 01 дугаар сарын 26-ны өдрийн 03/26, 2/520 дугаартай “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” албан бичиг болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дугаар хэсэгт заасан нөхцлөөр 2021 оныг хүртэлх хугацаанд шинээр тогтоолгосон өндөр нас авагчийн тэтгэврийн хувийн хэрэгт бүрдүүлсэн материалыг шалгав. Шалгалтаар 1396 өндөр насны тэтгэвэр авагчийн тэтгэврийг шалгаж 46 тэтгэвэр авагчтай холбоотой 758.4 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 42 тэтгэвэр авагчийн 633.5 ая төгрөгийн төлбөр зөрчлийг нотлон баталгаажуулж, 444.9 сая төгрөгийг төлүүлж үлдэгдэл 188.5 сая төгрөгийн төлбөрийг суутган тооцож барагдуулах ажил хийгдэж байна. Мөн 5 тэтгэвэр авагчийн 124.9 сая төгрөгийн төлбөр нотлогдоогүй, 1 тэтгэвэр авагчийн 14.7 сая нийт 5 иргэний 139.6 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

ДОЛОО. Тэтгэвэр, тэтгэмж тогтоолт олголтын талаар

Тэтгэвэр тогтоол олголтын талаар:

Тайлангийн хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас 22227 тэтгэвэр авагчид 186.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон.

Тайлангийн хугацаанд:

- Шинэ тогтоолгосон 2237 тэтгэвэр авагч
- Шилжиж ирсэн 297 тэтгэвэр авагч
- Шилжиж явсан 247 тэтгэвэр авагч
- Нас барсан 455 тэтгэвэр авагч байна.

Тэтгэвэр олголтын тайланг сар бүр хороо, арилжааны банкны салбараар нэгтгэн гаргаж, тэтгэврийн даатгалын сангийн зарлагын харилцахтай тохируулан зарлагын нягтлан бодогч, ерөнхий нягтлан бодогчоор сар бүр баталгаажуулан олгож ажиллалаа. Тэтгэвэр олголтыг долоо хоногийн баасан гариг бүр сард 5 удаа цахимаар банкуудад файлаар явуулж, хяналт тавин ажиллаж байна.

Шүүхийн шийдвэрээр тэтгэврээс суутган төлдөг тэтгэврийг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба, Банк, хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албанд хугацаанд нь шилжүүлэн ажилласан.



Тэтгэмж олголтын талаар:

- Тэтгэмжийн даатгалын сан:
 - хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 16376 даатгуулагчдад 3.7 тэрбум төгрөг
 - жирэмсэн амаржсаны тэтгэмж: 5990 даатгуулагчдад 16.9 тэрбум төгрөг
 - оршуулгын тэтгэмж: 2478 даатгуулагчдад 4.1 тэрбум төгрөг
 - ҮОМШӨ-ний даатгалын сан:
 - Тахир дутуугийн тэтгэврийг 114 даатгуулагчдад 1100.0 сая төгрөгний
 - Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 112 даатгуулагчдад 166.6 сая төгрөгний
 - Тэжээгчээ алдсаны 15 тэтгэвэр авагчдад 81.9 сая төгрөгний
 - Ажилгүйдлийн даатгалын сан:
 - ажилгүйдлийн тэтгэмж 2068 даатгуулагчдад 7.9 тэрбум төгрөгний
- тэтгэмжүүдийг тус тус тооцон олгосон байна.

Архивын ажлын талаар:

2023 онд тус хэлтсийн архивын сан хөмрөгт:

- Байнга хадгалах 546
- Түр хадгалах 4335
- 70 жил хадгалах 11915

Нийт 16796 ширхэг хадгаламжийн нэгж баримт тус тус хадгалагдаж байна.

2023 онд тус хэлтсийн архивын сан хөмрөгийн баримтаас лавлагаа авах хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, иргэд даатгуулагч, шүүх, цагдаагийн байгууллагуудад 8 төрлийн 29894 лавлагааг гарган өгч хурдан, шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд даатгуулагчид, шүүх, цагдаагийн байгууллагуудын хүсэлтээр архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа баримтаас тайлант хугацаанд:

№	Лавлагаа	Тоо /ширхэг/
1	1995 оноос хойшхи цалингийн лавлагаа	1702
2	Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй лавлагаа	137
3	Ажилласан жил нөхөн даатгалын лавлагаа	249
4	Шүүхийн шийдвэрээр болон Цагдаагийн хэлтсүүдэд олгосон лавлагаа	309
5	Өөр аймаг дүүргээс НДШ төлөлтийн лавлагаа авах хүсэлт явуулсан	486
6	Өөр аймаг дүүргээс ирсэн хүсэлтийг шийдвэрлэж, НДШ төлөлтийн лавлагаа гаргаж хүргүүлсэн	289
7	1991-1994 оны хоорондох НДШ төлөлтийн архивын лавлагаа	273
8	Даатгуулагчдад QR кодтой цалингийн лавлагаа олгосон, шинэ тэтгэвэр тэтгэмж авах даатгуулагчдад гаргаж хувийн хэрэгт хавсаргасан лавлагааны тоо	26450



	Нийт	29894
--	------	-------

Архивын ажлын 2023 оны ажлын төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөний биелэлтийг сар улирлаар тайлагнаж ажиллалаа.

Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулж, 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаатыг салбарын болон ерөнхий жагсаалтын дагуу нягтлан шалгаж шинэчлэн батлуулсан. 2022 оны архивын цаасан баримтыг хуулийн хугацаанд стандартын дагуу хадгаламжийн нэгж болгон бүрдүүлж архивт хүлээн авсан. Архивын улсын үзлэгтэй холбогдуулан бэлтгэл ажлыг ханган архивын өрөөнд шинэ 2 тавцан хийлгэж зогсоогдсон, байнга, түр, 70 жил хадгалах баримтуудыг шалгаж, төрөлжүүлэн байрлуулж, архивын өрөө тасалгааг стандартад нийцүүлэхээр шаардлагатай материалын судалгааг гарган ажиллаж байна.

Нэг цонхны үйлчилгээний ажлын талаар:

2023 оны гуравдугаар улирлын байдлаар Буян ХК, СБД ЗДТГ, Оргил худалдааны төвд нийтдээ 5609 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэн ажилласан байна.

Ирж үйлчлүүлж буй даатгуулагчдад нийгмийн даатгалын холбогдолтой хууль эрх зүйн зөвлөгөө тусалцааг үзүүлэхээс гадна даатгуулагчийн вэб программ, Гэрэгэсистем, Е баримт, E-Mongolia болон “Нийгмийн даатгал” аппликейшнуудыг суурилуулах, ашиглах, даатгуулагчид үнэ төлбөргүй нийгмийн даатгалын холбогдолтой мэдээлэл авах тухай болон ЭМД, СДД-ын төлбөрийг аппликейшнуудыг ашиглан хялбараар төлөх талаар зөвлөгөө өгч байна.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт байрлах 1 цэгийн үйлчилгээний төвөөр нийт 2274 иргэнд үйлчилгээ үзүүлэн ажилласан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгал 822 иргэн
- Сайн дурын даатгал 366 иргэн
- Нийгмийн даатгалын зөвлөгөө мэдээлэлийг 1086 иргэнд өгч ажилласан.
- Үйлчлүүлж буй иргэдийн тоон мэдээг 7 хоног бүрийн Пүрэв гарагт Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж буйтай холбогдуулан 187 иргэн QR уншуулж санал асуулгад хамрагдсан байна.

Оргил худалдааны төв 6 буудалд байрлах 1 цэгийн үйлчилгээний төвөөр нийт 1315 иргэнд үйлчилгээ үзүүлэн ажилласан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалд 625 иргэнийг хамруулсан
- Сайн дурын даатгал 87 иргэн
- Нийгмийн даатгалын зөвлөгөө мэдээлэл 603 иргэнд хүргэж ажилласан байна.

“Улаанбаатар Буян ХХК”-н нэг цэгийн үйлчилгээний төвд:

Улаанбаатар Буян ХХК-ын нэг цэгийн үйлчилгээний төвд 2023 онд 2478 иргэнд 4.1 тэрбум төгрөгийн оршуулгын тэтгэмж олгосон байна. Оршуулгын тэтгэмж авахаар ирж үйлчлүүлж буй иргэдэд нас барсны дараа сарын тэтгэвэр авах тухай, тэжээгчээ алдсаны тэтгэвэр хэрхэн авах, ямар материал бүрдүүлэх тухай зөвлөгөө өгч ажиллаж байна.




Тус дүүрэг нь улсын хэмжээнд оршуулгын тэтгэмж авагчдын 90 орчим хувьд оршуулгын тэтгэмж олгох үйлчилгээг үзүүлж байсан боловч 2023 оны 05 дугаар сарын 01-нээс Буян ХК дахь нэг цэгийн үйлчилгээ татан буугдаж дүүрэг тус бүр дээр оршуулгын тэтгэмжийг олгож байна.

НАЙМ.Хэлтсийн зохион байгуулж хийж гүйцэтгэсэн ажил болон дотоод ажлын талаар

Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагч иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад орон зай үл хамааран чирэгдэлгүй шуурхай үзүүлэх, нийгмийн даатгалын байгууллагын байцаагч ажилтнуудын харилцааны соёлыг сайжруулах, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор салбарын хэмжээнд 2023 оныг “Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил” болгон зарласан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ажил үйлчилгээгээ төлөвлөн явуулж ажиллаа.

Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, холбогдон гарсан хууль тогтоомж, дүрэм, журмын журмыг хэрэгжүүлэх, зөвлөгөө, мэдээ, мэдээлэл өгөх болон нийгмийн даатгалын ач холбогдолыг сурталчилах, хамрах хүрээг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг мэдээллийн технологийн дэвшил ашиглах замаар иргэд даатгуулагчдад түргэн, шуурхай, чирэгдэлгүй хүргэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор салбарын хэмжээнд 2023 оныг “Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил” болгон зарласан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ажил үйлчилгээгээ төлөвлөн явуулж ажиллаа.





СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

“Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга” болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, холбогдон гарсан хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлэх, зөвлөгөө, мэдээ, мэдээлэл өгөх болон нийгмийн даатгалын ач холбогдолыг сурталчилах, хамрах хүрээг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг мэдээллийн технологийн дэвшил ашиглах замаар иргэд даатгуулагчдад түргэн, шуурхай, чирэгдэлгүй хүргэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт болон Үлэмж grosерс ХХК, СБД-ийн Прокурорын газар, Сүхбаатар дүүргийн 1-20 дугаар хорооны нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нарт мөн “Цэвэр хөрсний шим дундын хоршоо”, Чингис хаан олон улсын нисэх буудлын Гаалийн газар, УБЕГ болон Онцгой байдлын ерөнхий газар, ОСНААҮАжилтны ҮЭХ-ны гишүүн байгууллагууд, Номин холдинг ХХК болон Нийслэлийн төрийн захиргааны байгууллагын захирал, нягтлан бодогч зэрэг 1200 орчим даатгуулагч, иргэдэд цахимаар болон танхимын сургалтын үйлчилгээний тасгийн дарга Ч.Эрдэнэчимэг, орлого шимтгэлийн тасгийн дарга Ё.Уранцэцэг, хяналт шалгалтын байцаагч Н.Гэрэлээ, магадлагч эмч Ж.Өнөгэрэл, сургалт сурталчилгаа хариуцсан байцаагч Д.Наранцацрал, нийгмийн даатгалын төлөөлөгч Н.Уранчимэг нар зохион байгуулан явуулав. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдрийн арга хэмжээний хүрээнд Сүхбаатарын талбайд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2023 оны 4 дүгээр сарын 26.27, 5 дугаар сарын 17.18-ны өдрүүдэд тус тус зохион байгуулав. Өдөрлөгөөр 500 гаруй иргэнд нийгмийн даатгал, эрүүл мэндийн болон сайн дурын даатгал, НД-ын цахим үйлчилгээ, нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдолын талаар болон хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгоор мэдээ, мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.





СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

Тус хэлтэст шинээр бүртгүүлсэн 496 аж ахуйн нэгж байгууллагын захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудад “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн шинэчилсэн найруулга, хуулинд орсон өөрчлөлт, хэрэгжилт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/182 дугаар “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан илгээх, хүлээн авах, хянах баталгаажуулах журам”-аар батлагдсан даатгуулагчийн төрөл кодод орсон өөрчлөлт болон шинээр батлагдан хэрэгжиж буй “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн талаар зөвлөгөө, мэдээ, мэдээлэл өгөх зорилгоор “Ажил олгогчийн зөвлөгөө”-ийг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17¹ дугаар зүйл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооноос баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс



шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө”-г үндэслэн жижиг, дунд үйлдвэрт ажиллагсад, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчид, бичил уурхай эрхлэгчидэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг 2023 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр тус тус сургалтыг зохион байгуулан явуулсан. Сургалтанд



248 аж ахуйн нэгж, байгууллагын захирал, нягтлан бодогч, ХАБЭА-н асуудал хариуцсан менежер, инженер, техникийн ажилтнууд хамрагдсан. Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хамтран тус дүүрэгт бүртгэлтэй АШУУИС, МУБИС, Сити Их сургууль, ИЗИС, Потунхуа зэрэг сургуулийн 1152 оюутан суралцагчдад “Даатгалтай ирээдүй-2023” сургалтыг 2023 оны 9 дүгээр сарын 11-25-ны өдрүүдэд зохион байгуулав.

Хэлтсийн 2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу байцаагч, айлтнуудын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор Сургалт судалгааны Полиси төвийн ерөнхий захирал, ахлах сургагч багш Г.Эрдэнэгэрэл “Байгууллагын соёл, дотоод орчин” сэдвээр, “Амьдрах Урлаг” ТББ-ын багш Т.Амгаланбаатар “Стрессийн түвшин тодорхойлох, стресс хэрхэн бий болдог, түүнээс хэрхэн ангижрах вэ?” сэдвээр, “Архив бичиг хэрэг хөтлөлт, анхаарах асуудал” сэдвээр Архивын Ерөнхий газраас, “Хувь хүний сэтгэл зүй ба харилцаа” сэдвээр Их засаг Их сургуулийн багш доктор профессор Д.Чинцэцэг, Авилгатай тэмцэх газрын мэргэжилтэн Д.Золжаргал “Авилгын гэмт хэрэг” “Анхан шатны яаралтай тусламж үйлчилгээг хэрхэн үзүүлэх, авах арга хэмжээ” сэдвээр Сүхбаатар дүүргийн Улаан Загалмайн нийгэмлэгийн дарга З.Өсөхбаяр, Нийслэлийн эрүүл мэндийн төв, Иргэдийн хэрэглээний боловсролын төвтэй хамтран



“Ажлын байран дах эрүүл зөв хооллолт, хамт олны харилцаа” сэдвээр сургалтуудыг танхимаар зохион байгуулан явуулав. Мөн Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц



СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газраас “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд албан хаагчдыг чадавхижуулах” сургалт, сурталчилгааны төлөвлөгөө-ний дагуу 2023 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр тус хэлтсийн албан хаагчдад сургалтыг зохион байгуулсан. Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалт хэлэлцүүлэгт тус хэлтсийн Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн болон бичиг хэрэг дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг 8 албан хаагч оролцов. МУИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилгыг хэрэгжүүлэх зорилгоор бүх шатны төрийн байгууллагын албан хаагчдыг шат дараалалтай хамруулах ажлын хүрээнд тус хэлтсийн 14 албан хаагчид 2023 оны 4 дүгээр сарын 20 болон 5 дугаар сарын 30-ны өдрүүдэд сургалтанд хамрагдсан. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах ажлын хүрээнд дүүргийн СБД-ийн 18 дугаар хороонд “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх Сэрэмжлүүлэг” хуудсыг тараан ажилласан. 18 дугаар хороо 11 хэсэгтэй бөгөөд нийгмийн даатгалын хоёр ажилтан 1 хэсгийн ахлагчийн хамт баг болон ажиллаж нийт 1294 өрх айлд тараасан байна.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/264 дүгээр захирамжаар батлагдсан “Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэн сайн мэдэх вэ?” сэдэвт мэдлэг сорих асуулт, хариултын тэмцээнийг АТГ-ын УССГХ, СБД ЗДТГ-аас Авлигын эсрэг “НЭГДЬЕ” аяны хүрээнд Сүхбаатар дүүргийн 14 төрийн байгууллагын дунд зохион байгуулж, тус хэлтсийн “Даатгал” баг гуравдугаар байр эзэлсэн амжилттай оролцсон.





СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

Улаанбаатар хотод 2023 оны 07 дугаар сарын эхээр үргэлжлэн орсон борооны улмаас үүссэн үерийн нөхцөл байдал, болзошгүй үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор үерийн ус хальсан болон халих эрсдэлтэй СБД-ийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт орших Сэлбэ, Дунд голын эрэг дагуух байршлуудад элс, хайрга, шороог зөөвөрлөн буулгаж, шуудайлан өндөрлөж хүчитгэх болон зөөвөрлөх, цэвэрлэх ажлуудад хэлтсийн эрэгтэй албан хаагчид 2023 оны 7 дугаар сарын 6-7-ны өдрүүд мөн 9 дүгээр сарын 5-6-нд шилжин шөнө тус тус ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигаар хүн амын орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг давах туулах бие сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг жил бүрийн дөрөвдүгээр сард зохион байгуулдаг ажлын хүрээнд дүүргийн Биеийн тамир спортын хороотой хамтран албан хаагчдаас бие бялдрын чийрэгжүүлэлтийн сорил авч, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалаар батлагдсан “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам”-ын дагуу “Family medical”-т урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэгт хамруулсан.





СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

Нийгмийн даатгалын алба үүсч хөгжсөний 81 жилийн ойг тохиолдуулан спортын арга хэмжээг Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран амжилттай зохион байгуулж явууллаа. Тэмцээн 2023 оны 05 дугаар сарын 11-14-ны өдрүүдэд Гар болон сагсан бөмбөг, дардас, Е спортын төрлөөр зохиогдож тус хэлтсийн эмэгтэй эрэгтэй гар бөмбөгийн баг хоёрдугаар, эрэгтэй сагсан бөмбөгийн баг гуравдугаар, дардасын төрөлөөр нэгдүгээр байр, багийн дүнгээр гуравдугаар байр эзэлсэн амжилтыг үзүүлж НДЕГ, ННДГ-ын удирдлага, дүүргүүдийн хэлтсийн дарга нараас сайн зохион байгуулсан гэсэн үнэлгээг авсан. Мөн Сүхбаатар дүүргийн хойд бүсийн төрийн албан хаагчдын дунд зохион байгуулан явуулсан спортын тэмцээнд багийн дүнгээр хоёрдугаар байр эзэлсэн амжилтыг үзүүлсэн байна.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “UB Marathon-2023” тэмцээний 5 км-ийн зайд 4 албан хаагч уралдаж амжилттай оролцсон.




Сүхбаатар дүүргийн Засаг даргын Албан даалгаварын дагуу 2023 оны 02 дугаар сарын 17, 4 дүгээр сарын 28-ны өдөр, 5 дугаар сарын 25-ны өдрүүдэд 3 удаа хариуцсан хэсэг болох Сэлбэгийн голын далан дагуу болон голын эргийн 800 метр орчим газар, 16 дугаар хорооны гуу жалгын хогийг цэвэрлэж дүн мэдээг sbd70070125@yahoo.com цахим хаягаар хүргүүлж ажилласан.





Хэлтсийн 19000 гаруй дагагчтай пейж хуудас болон facebook группээр нийгмийн даатгалын 5 сангаар 46 гаруй постер мэдээллийг давхардсан тоогоор 2369 удаа, 6 шторкийг давхардсан тоогоор 643 удаа, 4 удаагийн лайваар 9100 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч давхардсан тоогоор 1256 удаа нийтэлж, мессенжер чатаар 1481 иргэний асуултад хариулж АТГ, СБД ЗДТГ болон Жендерийн Үндэсний хорооноос зохион байгуулсан аянд нэгдэж ажилласан.



ЕС. Тайлант хугацааны үр дүнгийн талаар

Тайлангийн хугацаанд тус хэлтэс нь Монгол Улсын нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, салбарын харилцааг зохицуулж буй эрх зүйн актуудыг хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэхэд зохион байгууллалтын оновчтой хувилбараар ажиллаж аж ахуй нэгж байгууллага болон иргэдийг нийгмийн даатгалд хамруулан шимтгэл төлүүлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэх, даатгуулагч иргэдэд хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тогтоох, олгох ажлуудыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Интернэтээр нийгмийн даатгалын холбогдолтой хууль, тогтоомж, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах, сурталчилгаа хийх зорилгоор хэлтэс өөрийн www.ndaatgal.sbd.gov.mn вэб сайт болон “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын сан, Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс гэсэн 2 салбар эрхээр shilendans.gov.mn цахим хаягаар сар, улирал, хагас болон бүтэн жилээр ил тод тайлагнаж байна.

-----oOo-----



**ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ГУРАВДУГААР УЛИРЛЫН ЖИЛИЙН ТАЙЛАН**

2023 оны 10 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Тус хэлтэс нь 2023 оны гуравдугаар улирлын байдлаар Нийгмийн даатгалын тухай хууль болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Улсын их хурал, Засгийн газар, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны болон Нийслэл, Дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргын тушаал, шийдвэрийн биелэлтийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллав.

Нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь тавьж олгох, ажил олгогч, даатгуулагч иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх, дотоодын хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн үр дүнг дээшлүүлэх, 2023 оныг нийгмийн даатгалын салбарын хэмжээнд “Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил” болгон зарласан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ажил үйлчилгээгээ төлөвлөн явуулж ажиллаа.

**НЭГ. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт,
зарцуулалтын талаар**

2023 оны тодотгосон төсвөөр нийгмийн даатгалын санд 517.08 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын санд 87.0 тэрбум төгрөг нийт 604.08 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулахаар гуравдугаар улирлын байдлаар нийт 432.0 тэрбум төгрөгийг хуримтлуулж сангийн орлогын төлөвлөгөөг 100.3 хувиар биелүүлж ажиллаа.

Сар	Төлөвлөгөө /тэрбум төгрөгөөр/	Гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/	Биелэлтийн хувь
1-р сар	37.3	39.5	105.8
2-р сар	39.3	43.5	110.6
3-р сар	50.1	48.3	96.4
4-р сар	46.1	49.3	106.9
5-р сар	49.1	49.8	101.4
6-р сар	54.8	54.8	100.0
7-р сар	48.3	43.1	89.2
8-р сар	52.6	52.1	99.04
9-р сар	53	51.6	97.3
ДҮН	430.6	432.0	100.3

2023 оны гуравдугаар улирлын байдлаар нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг сан тус бүрээр нь авч үзвэл:



- Тэтгэврийн даатгалын сангаас 22165 тэтгэвэр авагчдад 132.8 тэрбум төгрөгний тэтгэвэр.
- Тэтгэмжийн даатгалын сангаас 17967 даатгуулагчдад 19.3 тэрбум төгрөгний тэтгэмж олгосноос:
 - Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 11550 даатгуулагчдад 2.6 тэрбум төгрөгний
 - Жирэмсэн амаржсаны тэтгэмж 4397 даатгуулагчдад 12.6 тэрбум төгрөгний
 - Оршуулгын тэтгэмж 2020 даатгуулагчдад 4.0 тэрбум төгрөгний
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 234 даатгуулагчдад 952.4 сая төгрөгийг олгосноос:
 - Тахир дутуугийн тэтгэврийг 114 даатгуулагчид 752.0 сая төгрөгний
 - Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 97 даатгуулагчдад 114.8 сая төгрөгний
 - Тэжээгчээ алдсаны 15 тэтгэвэр авагчдад 81.9 сая төгрөг
- Ажилгүйдлийн даатгалын сангаас 1543 даатгуулагчдад 5.7 тэрбум төгрөгний ажилгүйдлийн тэтгэмжийг тус тус олгосон байна.

**ХОЁР. Нийгмийн даатгалын хамралт, нийгмийн
даатгалын тайлан хүлээн авалт, мэдээллийн
сангийн бүрдүүлэлтийн талаар**

2023 онд нийгмийн даатгалын мэдээллийн баазыг Улсын бүртгэлийн баазтай холбосноор мэдээллийн санд даатгуулагчийн буруу регистр, овог нэр орохгүй байх үндсэн нөхцөл болж байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооны тайланг 100% интернэтээр авах зорилт тавьж ажилласны үндсэн дээр тайлан өгч байгаа 10205 байгууллагын тайланг вэбээр бүрэн авч хэвшсэн. Тоон гарын үсгээр тайлан өгөх ажлыг идэвхижүүлсээр сар бүр дунджаар 1391 аж ахуйн нэгж, байгууллагаас тоон гарын үсгээр ирж байгаа тайлангуудыг журмын дагуу хүлээн авч хэвшсэн байна.

Сар	Өглөг авлагын тайланд бүртгэлтэй аанб тоо	Тайлан өгсөн ААНБ тоо	Тоон гарын үсгээр тайлан өгсөн аан тоо	Заавал даатгуулагчийн тоо	Сайн дурын даат тоо
1-р сар	9625	6489	1351	103724	5352
2-р сар	9707	6342	1365	108035	5594
3-р сар	9778	6361	1351	113531	5809
4-р сар	9866	6667	1383	119271	6185
5-р сар	9885	6797	1395	119849	6372
6-р сар	9904	6927	1410	120427	6559
7-р сар	10074	6654	1379	135979	6800
8-р сар	10135	6689	1399	141195	6999
9-р сар	10205	6731	1391	147473	7202



2023 оны гуравдугаар улиралын байдлаар шинээр 624 аж ахуйн нэгж, байгууллагын 2409 заавал даатгуулагчийг нийгмийн даатгалд хамруулан ЗНД-7, ЗНД-8 тайланг хүлээн авч, нийгмийн даатгалын хуулийн талаарх зөвлөгөө, мэдээ мэдээллийг өгч ажиллав. 2023 оны гуравдугаар улиралын байдлаар 147473 албан журмын даатгуулагч бүртгэгдсэн байна. 2022 оны эцэст 6802 аж ахуйн нэгж, байгууллага тайлан өгч тооцоо хийж байсан бол 2023 оны гуравдугаар улиралын байдлаар 10205 байгууллага өр авлагын тайланд бүртгэгдсэнээс 8122 аж ахуйн нэг байгууллага тайлан өгч тооцоо хийж байгаа нь нийгмийн даатгалд хамрагдалтын хувь өмнөх оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад 119.4 хувь өссөн байна.

Цахим тайлан авах ажлыг зохион байгуулж нийт 14006 ажил олгогчид цахимаар тайлан өгөх нэвтрэх кодыг олгосноор, идэвхитэй тайлан өгч байгаа нийт 6731 ажил олгогч 100 хувь интернэтээр, 1391 аж ахуйн нэгж тоон гарын үсгээр тайлан өгч байна.

2023 онд мэдээллийн санд бүртгэгдсэн:

Нийт ажил олгогчийн тоо	-14680
Өглөг авлагын тайлангаар	-10205
Үүнээс Тайлан өгч байгаа	-8122
Үйл ажиллагаа зогсоосон, татан буугдсан, дампуурсан, сураггүй болсон	-7564
Заавал даатгуулагчийн тоо	-147473
Сайн дурын даатгуулагчийн тоо	-7202
ЭМД-д нийт хамрагдсан даатгуулагчдын тоо	-164457

2023 оны гуравдугаар улиралын байдлаар мэдээллийн сангийн үнэн зөв бүрдүүлэлтэд хяналт тавьж ажилласны дүнд буруу тайлагнасан ажилтнуудын цалин, даатгуулагчийн төрөлд нийт 384 аж ахуйн нэгж байгууллагын 598,8 сая төгрөгний залруулга хийв. Мөн сайн дурын ногдуулалт төлөлт зөрүүтэй 474 даатгуулагчийн баримтад шалгалт хийж 72.5 сая төгрөгийг залруулан мэдээллийн санд зөв дүнгээр оруулсан. Дотоодын хяналт шалгалтаар Цахим хяналтын програмаас даатгуулагчийн төрөл буруу орсон мэдээллийг шүүж залруулгын баримт бүрдүүлэн засаж байна.

Мэдээллийн санд буруу орсон 255 даатгуулагчийн овог нэр, регистрийг Улсын бүртгэлийн болон архивын лавлагаа, нийгмийн даатгалын дэвтэр, иргэний үнэмлэхийг үндэслэн нэгтгэж засав.

ГУРАВ. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага барагдуулалтын талаар

2022 оны жилийн эцсийн байдлаар 64.5 тэрбум төгрөг байснаас 2023 оны гуравдугаар улиралын байдлаар шимтгэлийн өр үүсгэсэн 4022 аж ахуйн нэгжийн 78.8 тэрбум төгрөг болж 22.1 хувиар өссөн дүнтэй байна. Үүнээс урсгал авлага 26.8 тэрбум төгрөг, хуримтлагдсан авлага 52.0 тэрбум төгрөгийн 120 хоногоос дээш насжилттай авлага, барагдуулсан 28.2 тэрбум төгрөг байна. Жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээг 60 хувиар бууруулахаар ажиллаж байна.



“Нийгмийн даатгалын шимтгэлийг үүссэн хугацаагаар нь ангилах журам”-ын дагуу өр авлагыг ангилж нийт зогсоогдсон 7105 байгууллагаас авлага үүссэгсэн 978 байгууллагын 343.1 мянган төгрөг, өглөг үүсгэсэн 1743 байгууллагын 326.8 мянган төгрөгийн өглөгийн судалгааг хийж, 1-4 дүгээр улиралд бууруулахаар ажиллаж байна. Нийт 37 аж ахуйн нэгжийн 525.7 сая төгрөгийн найдваргүй авлагын судалгааг гарган холбогдох анхан шатны материалын хамт НДЕГазарт хүргүүлж ажилласан.

Авлага нэмэгдэж байгаа өөр нэг шалтгаан нь 2020-2021 онд нийгмийн даатгалын шимтгэлийн хувь 3 хувиар, мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн, улирлын чанартай барилга, зам засвар, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагаагаа зогсоосон, шинээр үүсэх нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхгүй өр нэмэгдүүлэх болон аж ахуйн нэгжүүд өмнөх жилүүдийн хийсэн ажлын гүйцэтгэлээ, Сангийн яамнаас авч чадахгүй байгаа болон хөлсөөр ажил гүйцэтгэсэн санхүүжилт байхгүй, орлого орж ирэх боломжгүй байгаа гэсэн эдийн засгийн суурь шалтгаан нөхцлүүдээс үүдэн урсгал авлага өсч байна. Мөн цалин хөлсний доод хэмжээ 550000 мянган төгрөг болж нэмэгдсэн нь оны эхний үлдэгдэлээс өндөр дүнгээр авлага өссөн тоон үзүүлэлт харагдахад нөлөөлж байна. Аж ахуйн нэгж байгууллагууд нь график гарган хуримтлагдсан өр авлага барагдуулах гэрээ хийж байгаа боловч дээрх суурь нөхцөлөөс шалтгаалан тухайн сард шинээр үүсч байгаа шимтгэлийг төлж чадахгүй байгаа тохиолдлууд их байна.

Үзүүлэлт		2023 онд НДШ-н авлага барагдуулах журмын дагуу авсан арга хэмжээ			
		ААН	Өрийн хэмжээ	ААН	Барагдуулсан
"НДШ-н авлага бууруулах журмын дагуу авсан арга хэмжээ"	Уулзалт хийсэн аж ахуйн нэгж байгууллага	74	8.5 тэрбум ₮	35	638.7 сая ₮
	Өр барагдуулах УБ-н албан шаардлага өгсөн	47	2.3 тэрбум ₮	12	652.1 сая ₮
	Харилцах дансны зарлагын гүйлгээг хаасан	2153	52.9 тэрбум ₮	802	11.9 тэрбум ₮
	Журмын дагуу гэрээ байгуулж графикийн дагуу барагдуулсан	418	31.0 тэрбум ₮	130	11.7 тэрбум ₮
	Шүүхийн шийдвэр гаргуулсан	1	116.8 сая ₮	4	48.6 сая ₮

Дөрөв. Эрүүл мэндийн даатгалын сангийн төлөвлөгөө, биелэлт, хамрагдалтын талаар

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хооронд байгуулсан “Хамтарсан чиглэл хүргүүлэх тухай” чиглэлийг хэрэгжүүлж, Эрүүл мэндийн даатгалын санд 2023 онд нийт 87.0 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөг сар, улирал бүр жигд ханган биелүүлэхээс ажил олгогч даатгуулагчаас 83.8 тэрбум, бусад 3.8 тэрбум төгрөгийн орлогын татан төвлөрүүлэх зорилт тавин ажиллаж байгаагаас 2023 оны гуравдугаар улиралын байдлаар нийт 65.1 тэрбум төгрөг



СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

төвлөрүүлж ажилласан байна. Эрүүл мэндийн даатгалын хуримтлуулсан орлогыг төвлөрсөн харилцах дансанд тогтоосон хугацаанд бүрэн зөв хуваарилан ажилласан.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдагсдын тоог харуулбал:/хагас жилээр /

Нийгмийн даатгалд хамрагдагсад

01	Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагч	147473
10	Нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагчид	7202
		154675

ЭМД-ын заавал болон сайн дурын даатгалд хамрагдагсад

02	Аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	1
04	Мэргэжлийн сургуульд суралцагч	826
09	Малчин	0
12	Хоригдол	0
15	Гадаадын харъяалалтай иргэн	206
16	Нөхөн олговор авагч	0
18	Ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн	14176
99	Бусад /ОХУ-н ЭМД-ыг сайн дураар төлөгч/	0
		15209

Нийгмийн даатгалд хамрагдагсад

88	Нийгмийн даатгалд хамрагдагсад	164457
----	--------------------------------	--------

Нийт дүн: 169883

Тус хэлтэст бүртгэлтэй 26 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд бүх сургуулиудтай хамтран ажиллах санамж бичгийг байгуулж ажилласан. Мөн нийт 14 их дээд сургуулийн 1152 оюутан сурагчдад “Даатгалтай ирээдүй” сэдэвт сургалт зохион байгуулж ажилласан.

2023 оны эхний хагас жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр ЭМДаатгалд тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй 14176 иргэнийг, оюутан суралцагч 826, гадаадын харьяалалтай 206 иргэнийг хамруулсан байна. ЭМД-ын үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх ажлын хүрээнд дүүргийн иргэдээс гадна аймаг, хөдөө орон нутгийн иргэдийг харьяалал харгалзахгүй хүлээн авч түргэн шуурхай үйлчилж байна. Өглөгийг бууруулах ажлыг зохион байгуулж, хариуцсан ажилтнуудад үүрэг даалгавар өгч, өргөдөл гомдолыг цаг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан.

2023 онд эрүүл мэндийн даатгалын цахим үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг байцаагч нарын цахим хөтөчөөр дамжуулан зөвлөгөө өгч, ИБаримт системээр төлөлт хийх талаар даатгуулагчидад мэдээлэл өгч, 2019 оноос эхлэн эрүүл мэндийн даатгалын хураамжийг албан журмаар нөхөн төлүүлж ажиллаж байна



**ТАВ. Нийгмийн даатгалын сайн дурын
даатгалын сангийн төлөвлөгөө, биелэлт
хамралтын нэмэгдүүлэх талаар**

2023 оны сайн дурын даатгалд 6452 даатгуулагчийг хамруулж нийт 7.47 тэрбум төгрөг хуримтлуулахаас гуравдугаар улиралын байдлаар нийт 7202 даатгуулагчаас 6.5 тэрбум төгрөг хуримтлуулаж ажиллаа.

2022 оны эцэст сайн дурын даатгалын өглөг 181.8 сая төгрөг байсан бол 2023 оны гуравдугаар улиралын байдлаар 96.1 сая төгрөг болж 85.7 сая төгрөгөөр буурсан. Сайн дурын даатгалд шинээр 2425 даатгуулагчийг, 0-3 насны хүүхдээ асарч байгаа 256 ээжийг хамруулсан байна.

2023 онд мэдээллийн сангийн үнэн зав бүрдүүлэлтэд хяналт тавьж ажилсаны үр дүнд сайн дурын ногдуулалт, төлөлт зөрүүтэй 474 даатгуулагчийн баримтад шалгалт хийж залруулан мэдээллийн санд зөв дүнгээр оруулсан.

Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд УБЕГазрын хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн газраас Сүхбаатар дүүргийн хаягийн бүртгэлтэй шинээр бүртгүүлсэн 2124 аж ахуйн нэгж байгууллагын судалгааг авч 234 байгууллагыг шимтгэл төлөгчөөр бүртгэсэн. Татварын байгууллагад тайлан илгээж байгаа боловч нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан өгөхгүй байгаа аж ахуйн нэгжүүдийг хамруулах зорилгоор Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 238 дугаартай албан хүсэлт хүргүүлж, одоогоор хариу ирүүлээгүй байна.

Сүхбаатар дүүргийн Халамжийн хэлтэст “Цалинтай ээж” хөтөлбөрт хамрагдаж байгаа 4239 ээжийн судалгааг авч, 3 хүртэлх настай хүүхдээ асарч байгаа нярай ээжийн 155 гэрээг шинээр байгуулж, нийгмийн даатгалд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамрагдаж болох талаар холбогдож мэдээллийг утсаар хүргэн ажилласан.

ЗУРГАА. Хяналт шалгалтын ажлын талаар

2023 оны 3 дугаар улирлын байдлаар нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, хөдөлмөрийн хөлсний сан түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлсон байдал, нийгмийн даатгалын шимтгэл хураамжийн ногдуулалт, төлөлт, тайланг хугацаанд нь тушааж буй байдлыг нийт 159 ажил олгогчийн 3403 даатгуулагчийг хамруулан, улсын байцаагчийн актаар 49 ажил олгогчид 155.5 сая төгрөгийн хөдөлмөр хөлс түүнтэй адилтгах орлогын төлбөр зөрчлийн дүнгээс 54.6 сая төгрөгийн шимтгэл нөхөн төлүүлж, түүнээс 77.8 сая төгрөгийн алданги ногдуулж нийт 132.5 сая төгрөгийн төлбөр зөрчлийн дүнг 100% хувь барагдуулаад байна.

Нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь төлдөггүй, тайланг хугацаандаа тайлагнаагүй даатгуулагчийн эрх ашгийг хохироосон нийт 67 ажил олгогч байгууллагын захирал, нягтлан бодогчдод Зөрчилын тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.1, 10.17.2, 10.17.3, 10.17.4, 10.17.5 заалтын дагуу шийтгэврийн хуудсаар 26.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.

Дотоодын хяналт шалгалт хийх төлөвлөгөөт ажлын хүрээнд 2023 оны 03 дугаар улирлыг дуусталх хугацаанд шинээр тогтоогдсон 882 өндөр насны тэтгэвэр авагчийн 792.5 сая төгрөг, тэжээгчээ алдсаны 63 тэтгэвэр авагчийн 33.5 сая төгрөг,



тахир дутуугийн 266 тэтгэвэр авагчийн 145.0 сая төгрөг нийт 1211 тэтгэвэр авагчийн 971.1 сая төгрөгийн тэтгэврийн хувийн хэргийг шалгав. Үүнээс ажилласан хугацааг нотлох тушаалын хуулбар авах, сайн дурын даатгуулагчийн цуцласан гэрээг хавсаргах болон цалин буруу шивсэн, хувийн хэргийн хавтсанд хүлээж авсан материалын бүрдүүлэлтийг тэмдэглэдэггүй, ажилласан жил буруу тооцох зэрэг зөрчил гарсныг тухай бүр хариуцсан байцаагчаар нь засаж залруулан хянан шалгаж ажиллаж байна.

Мөн ХЧТА-ны 11550 даатгуулагчийн 2674.8 сая төгрөгийн тэтгэмж, жирэмсний болон амаржсаны 4397 даатгуулагчийн 12631.8 сая төгрөгийн, YOMШӨ-н ХЧТА-ны 97 даатгуулагчийн 114.8 сая төгрөгийн, сайн дурын даатгуулагчийн 467 хөдөлмөрийн чадвар түр алдсаны 253.4 сая төгрөгийн, жирэмсэн болон амаржсаны 303 тэтгэмжийн 454.1 сая төгрөгийн нийт 16814 даатгуулагчийн эмнэлгийн хуудасыг шалгаж 16128.9 сая төгрөгийн тэтгэмжийг хянаж олгуулав. Хяналт шагалтын явцад цалингийн дундаж буруу тооцох, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжтэй байгаа даатгуулагчийн цалинд төрөл буруу сонгох, шимтгэл төлөхгүй байх зэрэг зөрчлүүд илэрч тухай бүрд засаж залруулан ажиллаа. Мөн хяналтын monitoring программаар тэтгэмжийн бодолтын мэдээлэлийн бааз дээр байгаа алдааг шалгаж тайлбар шалтгааныг нь байцаагч тус бүрээр бичиж хааж байна.

Тайлант хугацаанд 2020 даатгуулагчдын 4040.5 сая төгрөгийн оршуулгын тэтгэмжийн олголт бодолт болон ажилгүйдлийн даатгалын сангаас 1543 даатгуулагчид олгосон 6779.1 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг шалгаснаас тэтгэмж авах хугацаандаа ажил хийсэн, цалин буруу шивсэн, цалинг нэгдсэн мэдээллийн санд шивээгүй бодолт хийсэн, ажилласан жилийг нотлох баримт дутуу зэрэг зөрчлийг тухай бүр нь засаж залруулав.

Дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн төлбөр зөрчил:

- Тэтгэмжийн даатгалын санд 34 даатгуулагчийн 21.5 сая төгрөгийг 100% төлүүлсэн.
- Тэтгэврийн даатгалын санд 82 иргэнтэй холбоотой 410.1 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 151.3 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж, барагдаагүй төлбөр 258.9 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, мөн хуулийн дагуу 50% хүртэлх хэмжээгээр суутган төлүүлж ажилласан.

Тус хэлтсийн дэргэдэх Эмнэлгийн хөдөлмөр магадлах комисс нь 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох асуудлыг магадлан шийдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж, энэ оны 3 дугаар улирлын байдлаар 21 өдөр буюу 181 цаг хуралдаж, 221 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шинээр тогтоох, 845 хүний хувь хугацааг сунгах, дүрмийн дагуу хөдөлмөрийн чадвар алдалт тогтоох нөхцөл шаардлагыг хангахгүй 13 хүнийг материал нөхөн бүрдүүлэхээр, эсвэл шийдвэрлэхээс татгалзаж буцаах, биеийн байдал сайжирсан, хяналтын хугацаа дууссан, өндөр насны тэтгэвэр тогтоолгох зэрэг шалтгаанаар 42 иргэний хувь хугацааг цуцлах байдлаар нийт 1121 даатгуулагчийн асуудлыг шийдвэрлэж ирсэн байна. Тус комисс нь иргэний харьяаллын дагуу шилжиж ирсэн 31, шилжиж явсан 4 иргэний



шилжилт хөдөлгөөнийг эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийг санд цаг тухайд нь хийж ажиллав.

- “Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах” №01 тоот удирдамж дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ээс 2022 оны 12 дугаар сарын 31-ныг дуустлах хугацааны 5078 ажилгүйдлийн тэтгэмжийг шалгаж зөрчилтэй байж магадгүй 48 даатгуулагчийн жагсаалтыг гаргасан.
- “Аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг шалгах” №02 тоот удирдамжийн дагуу нийт ажил олгогчийн массив 9785, үйл ажиллагаа зогссон 2912, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг 6873 аж ахуй нэгж байгууллагын тайланг шалгасан.
 - Мэдээллийн баазаас 3-НД7, 3-НД8 тайлан зөрсөн 16
 - Байгууллагын тамгагүй 893
 - Байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсэггүй 837
 - Дутуу тайлан 16
 - Нөхөнгийн тайлангийн албан бичиг баримт, цалин залруулгын баримт, карт зэрэг тайланд хавсаргаагүй 59
 - төрөл буруу тайлагнасан 1646 зөрчлийг илрүүлж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.
- “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг, шимтгэлийн хуримтлагдсан авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, хамралтыг нэмэгдүүлэх” №03 тоот удирдамжийн дагуу 121 хоногоос дээш шимтгэлийн хуримтлагдсан өртэй 792 аж ахуй нэгж байгууллагын 48.2 тэрбум төгрөгийн шимтгэлийг барагдуулан ажиллахаас 2023 оны эхний хагас жилийн байдлаар 145 байгууллагын 6.1 тэрбум төгрөгийг барагдуулаад байна
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн “Урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийх нэгдсэн удирдамж”-н дагуу Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсээс 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тогтоон авч байгаа 2355 иргэдийн судалгааг гаргуулж тус хэлтсээс тэтгэвэр авагч буй 22014 тэтгэвэр авагчийн мэдээлэлтэй тулган шалгаж 7 иргэнийн 31.7 сая төгрөгийн төлбөр зөрчлийг Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлж Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт улсын байцаагчийн акт тавигдсан.
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 01 дугаар сарын 26-ны өдрийн 03/26, 2/520 дугаартай “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” албан бичиг болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дугаар хэсэгт заасан нөхцлөөр 2021 оныг хүртэлх хугацаанд шинээр тогтоолгосон өндөр нас авагчийн тэтгэврийн хувийн хэрэгт бүрдүүлсэн материалыг шалгав. Шалгалтаар 1396 өндөр насны тэтгэвэр авагчийн тэтгэврийг шалгаж 46 тэтгэвэр авагчтай холбоотой 741.8 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 42 тэтгэвэр авагчийн 633.5 сая төгрөгийн төлбөр зөрчлийг нотлон баталгаажуулж, 409.9 сая төгрөгийг төлүүлж үлдэгдэл 223.6 сая төгрөгийн төлбөрийг суутган тооцож барагдуулах ажил хийгдэж байна. Мөн 4 тэтгэвэр авагчийн 108.3 сая төгрөгийн төлбөр нотлогдоогүй, 2 тэтгэвэр



авагчийн 27.9 сая нийт 6 иргэний 136.3 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.



**ДОЛОО. Тэтгэвэр, тэтгэмж тогтоолт
олголтын талаар**

Тэтгэвэр тогтоолт, олголтын талаар:

Тайлангийн хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас 22165 тэтгэвэр авагчид 132.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон.

Тайлангийн хугацаанд:

- Шинэ тогтоолгосон 1211 тэтгэвэр авагч
- Шилжиж ирсэн 139 тэтгэвэр авагч
- Шилжиж явсан 109 тэтгэвэр авагч
- Нас барсан 413 тэтгэвэр авагч байна.

Тэтгэвэр олголтын тайланг сар бүр хороо, арилжааны банкны салбараар нэгтгэн гаргаж, тэтгэврийн даатгалын сангийн зарлагын харилцахтай тохируулан зарлагын нягтлан бодогч, ерөнхий нягтлан бодогчоор сар бүр баталгаажуулан олгож ажиллалаа. Тэтгэвэр олголтыг долоо хоног бүрийн баасан гариг болон сар бүр 5 удаа цахимаар банкуудад явуулж, хяналт тавин ажиллаж байна.

Шүүхийн шийдвэрээр тэтгэврээс суутган төлдөг суутгалтай тэтгэврийг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба, Банк, хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албанд хугацаанд нь шилжүүлэн ажилласан.

Тэтгэмж олголтын талаар:

- Тэтгэмжийн даатгалын сан:
 - хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 11550 даатгуулагчид 2.6 тэрбум төгрөг
 - жирэмсэн амаржсаны тэтгэмж: 4397 даатгуулагчид 12.6 тэрбум төгрөг
 - оршуулгын тэтгэмж: 2020 даатгуулагчид 4.0 тэрбум төгрөг
- ҮОМШӨ-ний даатгалын сан:
 - Тахир дутуугийн тэтгэврийг 114 даатгуулагчид 752.0 сая төгрөгний
 - хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 97 даатгуулагчид 114.8 сая төгрөгний
- Ажилгүйдлийн даатгалын сан:
 - ажилгүйдлийн тэтгэмж 1543 даатгуулагчид 5.7 тэрбум төгрөгний тэтгэмжүүдийг тус тус тооцон олгосон байна.

Архивын ажлын талаар:



СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

2023 оны гуравдугаар улирлын байдлаар архивын сан хөмрөгийн баримтаас лавлагаа авах хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагч иргэн болон шүүх, цагдаагийн байгууллагуудад 7 төрлийн лавлагааг гарган ажиллалаа.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд даатгуулагчид, шүүх, цагдаагийн байгууллагуудын хүсэлтээр архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа баримтаас тайлант хугацаанд:

№	Лавлагаа	Тоо /ширхэг/
1	Цалингийн лавлагаа олгосон бүртгэл цаасан баримтаас	1349
2	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж авах эрх үүсээгүй	137
3	Нөхөн даатгалын лавлагаа	192
4	Шүүхийн шийдвэр, Цагдаагийн 1.2-р хэлтэст олгосон лавлагаа	458
5	Өөр аймаг дүүргээс НДШ төлөлтийн Архивын лавлагаа авах хүсэлт	225
6	Өөр аймаг дүүргээс ирсэн хүсэлтийг шийдвэрлэж, НДШ төлөлтийн Архивын лавлагаа явуулсан	300
7	1991-1994 оны аж ахуйн нэгж байгууллагын НДШ төлөлтийн лавлагаа	223
8	Даатгуулагчдын QRкодтой лавлагаа олгосон бүртгэл	835
	Нийт	3719

Архивын ажлын 2023 оны ажлын төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөний биелэлтийг сар улирлаар тайлагнаж ажиллалаа.

Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулж, 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаатыг салбарын болон ерөнхий жагсаалтын дагуу нягтлан шалгаж шинэчлэн батлуулсан. 2022 оны архивын цаасан баримтыг хуулийн хугацаанд стандартын дагуу хадгаламжийн нэгж болгон бүрдүүлж архивт хүлээн авсан. Архивын улсын үзлэгтэй холбогдуулан бэлтгэл ажлыг ханган архивын өрөөнд шинэ 2 тавцан хийлгэж зогсоогдсон, байнга, түр, 70 жил хадгалах баримтуудыг шалгаж, төрөлжүүлэн байрлуулж, архивын өрөө тасалгааг стандартад нийцүүлэхээр шаардлагатай материалын судалгааг гарган ажиллаж байна.

Нэг цонхны үйлчилгээний ажлын талаар:

2023 оны гуравдугаар улирлын байдлаар Буян ХК, СБД ЗДТГ, Оргил худалдааны төвд нийтдээ 11102 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэн ажилласан байна.

Ирж үйлчлүүлж буй даатгуулагчдад нийгмийн даатгалын холбогдолтой хууль эрх зүйн зөвлөгөө тусалцааг үзүүлэхээс гадна даатгуулагчийн вэб программ, Гэрэгэсистем, Е баримт, Е-Mongolia болон “Нийгмийн даатгал” аппликейшнуудыг суурилуулах, ашиглах, даатгуулагчид үнэ төлбөргүй нийгмийн даатгалын холбогдолтой мэдээлэл авах тухай болон ЭМД, СДД-ын төлбөрийг аппликейшнуудыг ашиглан хялбараар төлөх талаар зөвлөгөө өгч байна.



Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт байрлах 1 цэгийн үйлчилгээний төвөөр нийт 1805 иргэнд үйлчилгээ үзүүлэн ажиллсан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгал 702 иргэн
- Сайн дурын даатгал 250 иргэн
- Нийгмийн даатгалын зөвлөгөө мэдээлэлийг 853 иргэнд өгч ажилласан.
- Үйлчлүүлж буй иргэдийн тоон мэдээг 7 хоног бүрийн Пүрэв гарагт Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж буйтай холбогдуулан 187 иргэн QR уншуулж санал асуулгад хамрагдсан байна.

Оргил худалдааны төв 6 буудалд байрлах 1 цэгийн үйлчилгээний төвөөр нийт 860 иргэнд үйлчилгээ үзүүлэн ажиллсан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалд 402 иргэнийг хамруулсан
- Сайн дурын даатгал 78 иргэн
- Нийгмийн даатгалын зөвлөгөө мэдээлэл 380 иргэнд хүргэж ажилласан байна.

Иргэдэд үйлчлэх “Улаанбаатар Буян ХХК”-н нэг цэгийн үйлчилгээний төвд:



Улаанбаатар Буян ХХК-ын нэг цэгийн үйлчилгээний төвд 2023 оны эхний хагас жилд /ХБГ-р/ 2020 иргэнд 4.0 тэрбум төгрөгийн оршуулгын тэтгэмж олгосон байна. Оршуулгын тэтгэмж авахаар ирж үйлчлүүлж буй иргэдэд нас барсны дараа сарын тэтгэвэр авах тухай, тэжээгчээ алдсаны тэтгэвэр хэрхэн авах, ямар материал бүрдүүлэх тухай зөвлөгөө өгч ажиллаж байна.

Тус дүүрэг нь улсын хэмжээнд оршуулгын тэтгэмж авагчдын 90 орчим хувьд оршуулгын тэтгэмж олгох үйлчилгээг үзүүлж байсан боловч 2023 оны 05 дугаар сарын 01-нээс Буян ХК дахь нэг цэгийн үйлчилгээ татан буугдаж дүүрэг тус бүр дээр оршуулгын тэтгэмжийг олгож байна.



**НАЙМ.Хэлтсийн зохион байгуулж хийж
гүйцэтгэсэн ажил болон дотоод ажлын талаар**

Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагч иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад орон зай үл хамааран чирэгдэлгүй шуурхай үзүүлэх, нийгмийн даатгалын байгууллагын байцаагч ажилтнуудын харилцааны соёлыг сайжруулах, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор салбарын хэмжээнд 2023 оныг “Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил” болгон зарласан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ажил үйлчилгээгээ төлөвлөн явуулж ажиллаа. Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, холбогдон гарсан хууль тогтоомж, дүрэм, журмын журмыг хэрэгжүүлэх, зөвлөгөө, мэдээ, мэдээлэл өгөх болон нийгмийн даатгалын ач холбогдолыг сурталчилах, хамрах хүрээг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг мэдээллийн технологийн дэвшил ашиглах замаар иргэд даатгуулагчдад түргэн, шуурхай, чирэгдэлгүй хүргэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор салбарын хэмжээнд 2023 оныг “Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил” болгон зарласан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ажил үйлчилгээгээ төлөвлөн явуулж ажиллаа.





СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, холбогдон гарсан хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлэх, зөвлөгөө, мэдээ, мэдээлэл өгөх болон нийгмийн даатгалын ач холбогдолыг сурталчилах, хамрах хүрээг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг мэдээллийн технологийн дэвшил ашиглах замаар иргэд даатгуулагчдад түргэн, шуурхай, чирэгдэлгүй хүргэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт болон Үлэмж grosers ХХК, СБД-ийн Прокурорын газар, Сүхбаатар дүүргийн 1-20 дугаар хорооны нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нарт мөн "Цэвэр хөрсний шим дундын хоршоо"-ны албан хаагч нийт 680 гаруй даатгуулагч, иргэдэд цахимаар болон танхимын сургалтын үйлчилгээний тасгийн дарга Ч.Эрдэнэчимэг, орлого шимтгэлийн тасгийн дарга Ё.Уранцэцэг, хяналт шалгалтын байцаагч Н.Гэрэлээ, магадлагч эмч Ж.Өнөгэрэл, сургалт сурталчилгаа хариуцсан байцаагч Д.Наранцацрал нар зохион байгуулан явуулав. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтны өдрийн арга хэмжээний хүрээнд Сүхбаатарын талбайд "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг 2023 оны 4 дүгээр сарын 26.27, 5 дугаар сарын 17.18-ны өдрүүдэд тус тус зохион байгуулав. Өдөрлөгөөр 500 гаруй иргэнд нийгмийн даатгал, эрүүл мэндийн болон сайн дурын даатгал, НД-ын цахим үйлчилгээ, нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдолын талаар болон хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгоор мэдээ, мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.





ЭМДЕГ-тай хамтран тус дүүрэгт бүртгэлтэй АШУУИС, МУБИС, Сити Их сургууль, ИЗИС, Потунхуа зэрэг сургуулийн 1152 оюутан суралцагчдад “Даатгалтай ирээдүй-2023” сургалтыг 2023 оны 9 дүгээр сарын 11-25-ны өдрүүдэд зохион байгуулав.

Тус хэлтэст шинээр бүртгүүлсэн 496 аж ахуйн нэгж байгууллагын захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудад “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн шинэчилсэн найруулга, хуулинд орсон өөрчлөлт, хэрэгжилт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/182 дугаар “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан илгээх, хүлээн авах, хянах баталгаажуулах журам”-аар батлагдсан даатгуулагчийн төрөл кодоод орсон өөрчлөлт болон шинээр батлагдан хэрэгжиж буй “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн талаар зөвлөгөө, мэдээ, мэдээлэл өгөх зорилгоор “Ажил олгогчийн зөвлөгөө”-ийг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17¹ дугаар зүйл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооноос баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө”-г үндэслэн



жижиг, дунд үйлдвэрт ажиллагсад, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчид, бичил уурхай эрхлэгчидэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг 2023 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр тус тус сургалтыг зохион байгуулан явуулсан. Сургалтанд 248 аж ахуйн нэгж, байгууллагын захирал, нягтлан бодогч, ХАБЭА-н асуудал хариуцсан менежер, инженер, техникийн ажилтнууд хамрагдсан.





СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

Хэлтсийн 2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу байцаагч, айлтнуудын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор Сургалт судалгааны Полиси төвийн ерөнхий захирал, ахлах сургагч багш Г.Эрдэнэгэрэл "Байгууллагын соёл, дотоод орчин" сэдвээр, "Амьдрах Урлаг" ТББ-ын багш Т.Амгаланбаатар "Стрессийн түвшин тодорхойлох, стресс хэрхэн бий болдог, түүнээс хэрхэн ангижрах вэ?" сэдвээр, Архив бичиг хэрэг хөтлөлт, анхаарах асуудал сэдвээр Архивын Ерөнхий газраас, "Хувь хүний сэтгэл зүй ба харилцаа" сэдвээр Их засаг Их сургуулийн багш доктор профессор Д.Чинцэцэг, Авилгатай тэмцэх газрын мэргэжилтэн Д.Золжаргал "Авилгын гэмт хэрэг" "Анхан шатны яаралтай тусламж үйлчилгээг хэрхэн үзүүлэх авах арга" сэдвээр Сүхбаатар дүүргийн Улаан Загалмайн нийгэмлэгийн дарга З.Өсөхбаяр нар танхимын сургалтыг зохион байгуулав. Нийслэлийн эрүүл мэндийн төв, Иргэдийн хэрэглээний боловсролын төвтэй хамтран "Ажлын байран дах эрүүл зөв хооллолт, хамт олны



харилцаа" сэдвээрх сургалтыг 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулан явуулав. Мөн Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газраас "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд албан хаагчдыг чадавхижуулах сургалт, сурталчилгааны төлөвлөгөө"-ний дагуу 2023 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр тус хэлтсийн албан хаагчдад сургалтыг зохион байгуулсан.



МУИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилгыг хэрэгжүүлэх зорилгоор бүх шатны төрийн байгууллагын албан хаагчдыг шат дараалалтай сургалтанд хамруулах ажлын хүрээнд тус хэлтсийн 14 албан хаагчид 2023 оны 4 дүгээр сарын 20 болон 5 дугаар сарын 30-ны өдрүүдэд сургалтанд хамрагдсан.

Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах ажлын хүрээнд дүүргийн СБД-ийн 18 дугаар хороонд “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх Сэрэмжлүүлэг” хуудсыг тараан ажилласан. 18 дугаар хороо 11 хэсэгтэй бөгөөд нийгмийн даатгалын хоёр ажилтан 1 хэсгийн ахлагчийн хамт баг болон ажиллаж нийт 1294 өрх айлд тараасан байна.



Улаанбаатар хотод 2023 оны 07 дугаар сарын эхээр үргэлжлэн орсон борооны улмаас үүссэн үерийн нөхцөл байдал, болзошгүй үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор үерийн ус хальсан болон халих эрсдэлтэй СБД-ийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт орших Сэлбэ, Дунд голын эрэг дагуух байршлуудад элс, хайрга, шороог зөөвөрлөн буулгаж, шуудайлан өндөрлөж хүчитгэх болон зөөвөрлөх, цэвэрлэх ажлуудад хэлтсийн эрэгтэй албан хаагчид 2023 оны 7 дугаар сарын 6-7-ны өдрүүд мөн 9 дүгээр сарын 5-6-нд шилжин шөнө тус тус ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигаар хүн амын орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг давах туулах бие сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг жил бүрийн дөрөвдүгээр сард зохион байгуулдаг ажлын хүрээнд дүүргийн Биеийн тамир спортын хороотой хамтран албан хаагчдаас бие бялдрын чийрэгжүүлэлтийн сорил авч, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалаар батлагдсан “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам”-ын дагуу “Family medical”-т урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэгт хамруулсан.



СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС



Нийгмийн даатгалын алба үүсч хөгжсөний 81 жилийн ойг тохиолдуулан спортын арга хэмжээг Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран амжилттай зохион байгуулж явууллаа. Тэмцээн 2023 оны 05 дугаар сарын 11-14-ны өдрүүдэд Гар болон сагсан бөмбөг, дардас, Е спортын төрлөөр зохиогдож тус хэлтсийн эмэгтэй эрэгтэй гар бөмбөгийн баг хоёрдугаар, эрэгтэй сагсан бөмбөгийн баг гуравдугаар, дардасын төрөлөөр нэгдүгээр байр, багийн дүнгээр гуравдугаар байр эзэлсэн амжилтыг үзүүлж НДЕГ, ННДГ-ын удирдлага, дүүргүүдийн хэлтсийн дарга нараас сайн зохион байгуулсан гэсэн үнэлгээг авсан. Мөн Сүхбаатар дүүргийн хойд бүсийн төрийн албан хаагчдын дунд зохион байгуулан явуулсан спортын тэмцээнд багийн дүнгээр хоёрдугаар байр эзэлсэн амжилтыг үзүүлсэн байна.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “UB Marathon-2023” тэмцээний 5 км-ийн зайд 4 албан хаагч уралдаж амжилттай оролцсон.



СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС




Сүхбаатар дүүргийн Засаг даргын Албан даалгаварын дагуу 2023 оны 02 дугаар сарын 17, 4 дүгээр сарын 28-ны өдөр, 5 дугаар сарын 25-ны өдрүүдэд 3 удаа хариуцсан хэсэг болох Сэлбэгийн голын далан дагуу болон голын эргийн 800 метр орчим газар, 16 дугаар хорооны гуу жалгын хогийг цэвэрлэж дүн мэдээг sbd70070125@yahoo.com цахим хаягаар хүргүүлж ажилласан.



Сүхбаатар Дүүрэг Нийгмийн Даатгалын Хэлтсийн 19000 гаруй дагагчтай цахим хуудас болон facebook группээр нийгмийн даатгалын 5 сангаар 62 постер, 500 гаруй даатгуулагч иргэдийн асуултад харилж, 4 удаагийн LIVE-аар нийт 9100 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 218 иргэний асуусан асуултад хариулж, 600 гаруй сурталчилгааны материал тараан, 23 постер мэдээллийг хуваалцаж, АТГ, СБД ЗДТГ болон Жендерийн Үндэсний хорооноос зохион байгуулсан аянд нэгдэж ажилласан.



СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС



ЕС. Тайлант хугацааны үр дүнгийн талаар

Тайлангийн хугацаанд тус хэлтэс нь Монгол Улсын нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, салбарын харилцааг зохицуулж буй эрх зүйн актуудыг хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэхэд зохион байгууллалтын оновчтой хувилбараар ажиллаж аж ахуй нэгж байгууллага болон иргэдийг нийгмийн даатгалд хамруулан шимтгэл төлүүлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэх, даатгуулагч иргэдэд хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тогтоох, олгох ажлуудыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Интернэтээр нийгмийн даатгалын холбогдолтой хууль, тогтоомж, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах, сурталчилгаа хийх зорилгоор хэлтэс өөрийн www.ndaatgal.sbd.gov.mn вэб сайт болон “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга. Нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу хэлтсийн даргын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/24 тоот “Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нэвтрэн мэдээлэл, хяналт тавих ажилтныг томилох тухай” тушаалаар томилогдсон албан хаагчид нь байгууллагын үйл ажиллагааны 20 төрлийн 117 мэдээлэл, Нийгмийн даатгалын сангийн 21 төрлийн 112 мэдээллийг тухай бүр, сар бүр, улирал бүр, хагас жил бүр, жил бүр гэсэн давтамжтайгаар үнэн зөв, хуулийн хугацаанд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт байршуулан ажиллаж байна.

